

NEWS

Эрдэмтдийн индэр**ТҮҮХИЙН ШИНЖЛЭХ УХААНЫГ
ТҮҮЧЭЭЛЖ ЯВАА ЗАЛУУ ЭРДЭМТЭН**

Дэлхий ертөнцөд шинжлэх ухаан, технологи нэн хурдацтай хувьсан өөрчлөгдөж байгаа шинэ зууны эхэнд Монголын түүхийн шинжлэх ухааныг түүчээлэн авч яваа залуу эрдэмтэн бол Хар Адуутан Сампилдондовын Чулуун юм. Түүний эрдэм боловсрол, чөлөөт сэтгэлгээ, эрч хүч, хичээл зүтгэл, удирдан зохион байгуулах авьяас чадвар нь өнөөдөр Монголын түүх судлалын “хөдөлгөгч хүч” болж байна.

Хар Адуутан С.Чулуун 1977 оны 7 дугаар сарын 14-нд Төв аймгийн Баянцагаан сумын нутаг “Зогсоол” хэмээх газар малчин ард Сампилдондовын хүү болон хүй цөглөжээ. Тэрбээр 1995 онд Төв аймгийн Зуун мод хотод ерөнхий боловсролын дунд сургууль төгсөж, МУИС-ийн түүхийн ангид элсэн орсноор ирээдүйн амьдралын зам нь эхэлжээ.

С.Чулуун МУИС-ийг түүхч, түүхийн багш мэргэжлээр төгсөж, 1999 оноос ШУА-ийн Түүхийн хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтан, МУИС-ийн Түүхийн тэнхимд багш, салбарын эрдэмтэн нарийн бичгийн даргаар ажиллаж, 2010 оноос ШУА-ийн Түүхийн хүрээлэн, 2015 оноос Түүх, археологийн хүрээлэнгийн захирлаар ажиллаж, 2010 онд дэд профессор, 2016 онд профессор цол хүртжээ. С.Чулуун 2005 онд ОХУ-ын Москва хотод “XIX-XX зууны зааг үеийн умард Монголын нийгэм-эдийн засаг, угсаа соёлын асуудал” сэдвээр түүхийн ухааны доктор (Ph.D)-ын, 2017 онд Монгол улсад “XVII зууны Монголын гадаад ертөнц: Орос, Манж Чин улсын харилцааны түүх” сэдвээр түүхийн шинжлэх ухааны доктор

(Sc.D)-ын зэрэг хамгаалж, 2008, 2010, 2011 онд Английн Кембридж Их Сургуулийн “Дотоод Ази ба Монгол судлал”-ын төвд зочин судлаач, 2012-2013, 2014 онд Японы Осака хотын Үндэсний Угсаатны музей, Тохоку Их сургуулийн Зүүн хойд Азийн судлалын төвд, 2015 онд Унгарын ШУА-ийн Угсаатны судлалын хүрээлэнд, 2017 онд БНХАУ-ын Ардын Их Сургуульд тус тус зочин профессороор уригдан ажиллажээ. Эдгээр амжилт нь тэрбээр богино хугацааны дотор Монголын түүхийн шинжлэх ухааны манлайд гарч, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нэртэй эрдэмтэн болж чадсаныг нотлон харуулж байна.

Профессор С.Чулуун Монголын түүх, угсаатны зүйн салбарт олон чиглэлээр судалгаа явуулж байгаагийн дотроос XVII зууны Монголын түүх, Монгол-Оросын харилцаа, Монголын түүхэн угсаатны зүй, түүхийн эх сурвалж, архивын баримт, XX зууны эхэн үеийн Монголын улс төр, нийгэм, соёл, шинжлэх ухааны зүтгэлтнүүдийн намтар, үйл ажиллагааны асуудал гол байр суурийг эзэлж байна.

Түүний судалгааны анхдагч чиглэл нь “Хотогойд судлал” бөгөөд Монголын умард хэсэгт нутаглах Хотогойдуудын түүх, угсаатны зүйн чиглэлээр дагнан судалж, “Хотогойдын түүх” (УБ.,2006), “Хотогойд судар” (УБ.,2007) зэрэг шинэлэг бүтээлүүдийг туурвин “Хотогойд судлал”-ыг шинэ төвшинд гаргасан учир “Хотогойд Чулуун” хэмээх нэрийг олжээ. Хотогойдын нийгэм-эдийн засаг, угсаа, соёлын хөгжил, Монголын нийгэмд гүйцэтгэсэн үүрэг, байр суурийг шинээр авч үзэж, тэднийг түрэг

гаралтай хэмээсэн судлаачдын саналыг шинжлэх ухааны үндэс нотолгоотойгоор няцаасан түүний бүтээлүүд нь угсаатны түүхийн судалгаанд шинэлэг ажил болж, цаашид Монголын угсаатны бүлгүүдийг түүх, угсаатны зүйн талаас нь шинжлэн судлах арга зүйн үндсийг бүрдүүлжээ.

Профессор С.Чулуун “түүхийн цагаан толбо” болж байсан XVII-XVIII зууны монголчуудын түүхийг бүс нутгийн хэмжээнд, цогц байдлаар



Төв аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Сарьдагийн хийдийн малтлага судалгааны багийхан 2015 он

нэгтгэн судалснаар Монголчууд нь Манж, Оросын эзэнт гүрнүүдийн нөлөөнд орж, хүч нөлөөгөө алдсан бус харин ч Дотоод Азийн бүс нутагт нэгдмэл нэг үндэстэн хэвээр байж, бүс нутгийнхаа улс төр, эдийн засаг, дипломат харилцаанд томоохон үүрэгтэй байсныг нээн илрүүлжээ. Энэ үндсэн дээр өгүүлэн буй үеийн Монголын түүхийг тодорхой нэг газар нутаг, угсаатны бүлгийн төвшинд бус, харин нэгдсэн системийн хүрээнд, цогц байдлаар судлах арга зүйн үндэслэлийг боловсруулсан байна. Судалгааны энэхүү шинэлэг арга зүй, агуулгаар туурвисан бүтээлүүдээс хамгийн дорвитой нь түүхийн шинжлэх ухааны доктор (Sc.D)-ын зэрэг хамгаалсан “XVII зууны Монголын гадаад ертөнц: Орос, Манж Чин улсын харилцааны түүх”

нэгэн сэдэвт зохиол юм. Энэхүү бүтээлээр Монголын түүхчид өрнө, дорнын улс орнуудын аль нэг дэг сургуулийг дагах бус харин өөрийн гэсэн судалгааны чиг хандлагыг тогтоох шаардлагатайг нотолж, тэрхүү чиг хандлагын үндэс суурийг тавьснаараа Монголын түүхийн шинжлэх ухаанд дорвитой хувь нэмэр оруулсан юм.

Профессор С.Чулуун нь Монгол улсын шинжлэх ухааны салбарын үүсэл, хөгжилд томоохон үүрэг гүйцэтгэж байсан бичгийн мэргэд, эрдэмтдийн талаар хэд хэдэн өгүүлэл, ном нийтлүүлжээ. Үүнд: Судар бичгийн хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Ж.Цэвээн, Шинжлэх ухааны хүрээлэнгийн дарга Л.Дэндэв, Монголын ууган археологич Х.Пэрлээ, ШУА-ийн анхны ерөнхийлөгч Б.Ширэндэв нарын тухай дорвитой судалгаа хийжээ. Түүнчлэн Оросын ШУА-ийн Техник, шинжлэх ухааны

түүхийн хүрээлэнтэй хамтран “Орос-Монголын шинжлэх ухааны харилцаа: Судар бичгийн хүрээлэнгээс Шинжлэх Ухааны академи хүртэл” (УБ-Санкт-Петербург, 2012) хамтын бүтээлийг орос хэлээр нийтлүүлсэн нь Монгол-Оросын шинжлэх ухааны хамтын ажиллагааны судалгааг гүнзгийрүүлж, шинэ шатанд гаргах нөхцөлийг бүрдүүлсэн бүтээл болсон юм.

Профессор С.Чулуун Монголд “социализм байгуулах” үеийн судалгаанд анхаарлаа хандуулж, “Монголын сангийн аж ахуйн түүх” номыг Японы Осакагийн Үндэсний Угсаатны музейд япон, монгол хэлээр хэвлүүлснээс гадна XX-XXI зууны зааг үеийн Монголын нийгмийн түүхийг “хөшөө дурсгал”-аар дамжуулан судлах

шинэлэг арга зүйг боловсруулжээ. Энэ үндсэн дээр “Посткоммунист үеийн Монгол дахь хөшөө ба улс төр” (2014 он) хэмээх сонирхолтой ном бичив. Энэ бүтээлээрээ хөшөө дурсгал нь зөвхөн урлагийн бүтээл төдий бус, мөн эрин цагийнхаа нийгмийн сэтгэлгээ, үзэл хандлагыг илэрхийлсэн судлагдахуун болохыг нотолж, Монголын түүхийн судалгаанд “хөшөө дурсгалын судалгаа” хэмээх нэгэн шинэлэг чиглэлийг тогтоосон хэмээн дүгнэж болно.

Түүхийн шинжлэх ухааны доктор С.Чулуун нь Монголын түүхийн эх сурвалж, архивын баримтын судалгаанд томоохон хувь нэмэр оруулж байгаа эрдэмтэн юм. 2002 онд Олон улсын Монголч эрдэмтдийн VIII Их хуралд зориулан “Засагт хан аймгийн чухал хэргийн данс” хэмээх ном хэвлүүлж, XVIII-XIX зууны үеийн Халхын Засагт хан аймгийн түүхэнд хамааралтай ховор баримтыг судалгааны эргэлтэд оруулж эхэлснээс хойш эх түүхийн ховор чухаг сурвалж, архивын баримтуудыг олж илрүүлэн, хэвлэн нийтлүүлэх ажлыг тасралтгүй явуулж иржээ. Мөн XVII зууны Монголын түүхийн цөөн хэдэн эх сурвалжийн нэг болох “Шар тууж”-ийн нэгэн шинэ хувилбарыг олж илрүүлэн судалгааны эргэлтэд оруулсан нь Монголын түүхийн шинжлэх ухаанд оруулсан түүний том хувь нэмрийн нэгэнд зүй ёсоор тооцогдоно. Учир нь, тэрхүү бүтээлийг Монголын болон гадаадын эрдэмтэд чухалчлан үзэж, эдүгээ орос, хятад хэлээр орчуулсан бөгөөд олон улсын төвшинд “Чулууны Шар тууж” хэмээн нэрлэгдээд байна.

Сурвалж, эх бичгийн судалгааны зэрэгцээгээр орон нутагт хээрийн судалгаа явуулж Өмнөговь аймгийн Ханбогд сум,

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумаас хадны бичээс, Төв аймгийн Баянцагаан сумын нутгаас Монголын эзэнт улсын түүхэнд холбогдох хоёр хүн чулууг илрүүлэн шинжилж, мэдээлсэн байна. Түүнчлэн Завхан аймгийн Баянтэс сумын нутаг дахь XVII зууны үеийн нэгэн хотын үлдэгдэл “Сүмийн толгой”, ОХУ-ын Красноярскийн тойргийн нутгаас 1660-аад онд Монголын Алтан хаан Лувсанринчины байгуулсан “Упса голын



Доктор (Sc.D), профессор С.Чулуун ОХУ-ын ШУА-ийн Дорнодахины гар бичмэлийн хүрээлэнгийн захирал И.Ф.Поповатай хамт тус хүрээлэнгийн музейд. Санкт-Петербург хот 2013 он.

хот”-ын туурийг хайн олж, хээрийн судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл бичиж нийтлүүлжээ. Өндөр гэгээн Занабазарын байгуулсан “Номын их хүрээ” буюу “Сарьдаг хийд”-ийг ирүүлж, Түүх, археологийн хүрээлэнгийн судалгааны ангийг 2013 оноос хойш ажиллуулж, малтлага судалгаа явуулж байна. алтлага, судалгааны дүнд Сарьдагийн хийд нь Өндөр гэгээн Занабазарын байгуулсан нэн өвөрмөц хүрээ хийд, уран бүтээлийн гол ордон байсныг нотолж, 2018 онд томоохон хэмжээний үзэсгэлэн гаргахаар бэлтгэж байна.

Гадаадын улс орнуудад хадгалагдаж байгаа Монголын түүхэнд холбогдох сурвалж, гэрэл зураг, эх хэрэглэгдэхүүнийг

хуулбарлан авч эх түүхийн судалгааны баазыг өргөжүүлэх, тэдгээрийг хэвлэн нийтлэх ажлыг хамгийн эрчимтэй хийж буй эрдэмтэн бол С.Чулуун билээ. Тэрбээр ОХУ-ын төв, орон нутгийн архивууд, мөн Япон, БНХАУ, Англи, Польш, Унгар улсын архив, музей, номын санд ажиллаж, Монголын түүхтэй холбоотой, урьд өмнө



Доктор (Sc.D), профессор С.Чулуун, ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины хүрээлэнгийн захирал, академич В.В.Наумкин, алдарт хятад судлаач академич С.П.Мясников нарын хамт. Москва хот. 2010 он

судалгааны эргэлтэд ороогүй баялаг материалыг олж илрүүлэн Монголд улсдаа хуулбарлан авчирч хэд хэдэн баримтын эмхтгэл болон эх хэрэглэгдэхүүнийг хэвлэн гаргаад байна.

Профессор С.Чулуун түүхэн гэрэл зургуудыг судлах, гэрэл зургаар дамжуулж түүхэн үзэгдэл, үйл явдлыг тодруулах, бичмэл эх сурвалжийг түүхэн гэрэл зургаар давхар нотлох буюу илүү тодорхой болгох чиглэлд томоохон алхмуудыг хийж байгаа нь түүхийн судалгааны бас нэгэн шинэлэг арга зүй, хандлага болж байна. Энэ ажлын хүрээнд “Монголчууд түүхэн гэрэл зурагт” хэмээх долоон боть ном гаргахаар төлөвлөн ажиллаж, эхний гурван боть болох “Монгол Улсын анхны Ерөнхий сайд Оросын эзэнт улсад” (Түүх-гэрэл зураг) /УБ.2014/, “Монголия и Монголы-I” , “Монголия и Монголы-II” /СПб-УБ. 2015, 2017/ гэрэл

зургийн цомгуудыг хэвлүүлээд байна. Эдгээр цомогт ОХУ-ын Москва, Санкт-Петербург хоть дахь томоохон хүрээлэн, архивт хадгалагдаж байгаа XX зууны эхэн үеийн Монголын тухай 3000 орчим гэрэл зураг багтсан нь Монголын бодит байдлыг тухайн цаг үеийнх нь өнгө төрхөөр, олон талаас нь харуулж байгаагаараа судалгаа, танин мэдэхүйн хувьд үнэ цэнэтэй болжээ.

Доктор С.Чулуун нь эрдэм судлалын ажилд шамдсан хориод жилийн хугацаанд Монголын түүх, угсаатан судлалын чиглэлээр нэгэн сэдэвт болон хамтын бүтээл 20 гаруй, эрдэм шинжилгээний өгүүлэл 80 орчмыг нийтлүүлж, үндэсний хэмжээний болон олон улсын хуралд 60 гаруй удаа илтгэл хэлэлцүүлж, Монголын болон гадаадын монголч эрдэмтдийн 20 гаруй бүтээлийн редактор, зөвлөхөөр ажиллаж, толь, сурах бичиг, лавлах материал 20 орчмыг хэвлүүлжээ. Түүний бүтээл Их

Британи, БНСУ, БНХАУ, Нидерланд, ОХУ, Япон улсын мэргэжлийн сэтгүүлүүдэд нийтлэгдснээс гадна “ХIII Далай ламын дүрвэлт” ном нь Дотоод Азийн судалгааны хувьд дэлхийд тэргүүлэх хэвлэлийн газар болох “Brill”-д, “Монголын Бурханы шашны соёл”, “Сангийн аж ахуйн түүх” бүтээл нь Японы Осака Үндэсний Угсаатны музейн “Senri Ethnologica”-д цувралаар тус тус гарсан нь Монголын түүх судлалын төвшин, хувь эрдэмтний чансааг харуулж байна хэмээн үзэж болно.

Профессор С.Чулуун Монгол судлалыг дэлхийн төвшинд гаргахад үнэтэй хувь нэмэр оруулж байна. Дөрвөн жил тутамд дэлхийн нэр хүндтэй Их сургууль, судалгааны газруудад зохион байгуулагддаг “Дэлхийн Түвд судлалын Их хурал”-ыг түүний санаачилга, удирдлагаар Монгол улсад анх удаагаа 2013 оны 7 дугаар сарын 19-27-нд

зохион байгуулав. Мөн ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн 2013 оноос эхлэн Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Монголчуудын бичгийн дурсгал, архивын баримт” олон улсын хурлыг ОХУ-ын Санкт-Петербург хотноо хоёр удаа, Монгол улсад нэг удаа тус тус зохион байгуулсан нь эдүгээ олон улсын эрдэмтэд оролцдог шинжлэх ухааны томоохон чуулган болон өргөжиж буйг дурдах нь зүйтэй байна.

Доктор С.Чулуун нь 2016 онд хуралдсан Олон улсын Монголч эрдэмтдийн XI Их хурлаас Олон Улсын Монгол Судлалын Холбооны Ерөнхий нарийн бичгийн даргаар сонгогдон ажиллаж байгаа бөгөөд Дэлхийн түүхчдийн холбооны албан ёсны гишүүн юм. Түүнчлэн Английн Кембрижийн Их сургуулийн “Inner Asia archives materials” цуврал, Оросын ШУА-ийн Сибирийн салбарын Буриадын эрдэм шинжилгээний төвийн “Вестник БНЦ СО РАН”, Эрхүү хотын Байгалийн Их сургуулийн “Вестник Университета” сэтгүүлийн Зөвлөл, Редакцийн зөвлөлүүдийн гишүүнээр ажиллаж байна.

Профессор С.Чулуун бол шилдэг залуу эрдэмтэн төдийгүй шинжлэх ухааны чадварлаг зохион байгуулагч, авьяаслаг менежер юм. Түүнийг ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн захирлаар ажиллах хугацаанд Монголын түүх судлал урьд өмнөхөөс өргөн цар хүрээтэй явагдаж, судалгааны агуулга, арга зүй, бүтээлийн тоо болон чанар, судлаачдын чадамжид эрс өөрчлөлт гарч эхэлснээр түүхийн шинжлэх ухааны хөгжилд нэгэн шинэ үеийг эхлүүлсэн хэмээн үзэж болно. Өнөөдөр Монголын түүх, археологийн цөм судалгаа, суурь бүтээлүүд ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнд явагдаж байгаатай хэн ч маргахгүй байх. Тус хүрээлэнд жилдээ 20 орчим улсын 40 гаруй удаагийн хээрийн судалгаа явагдаж, 10 орчим Үндэсний судалгааны баг ажиллаж байна. “Монголын археологийн үнэт өв” зургаан боть, “Монголын археологийн судалгааны тайлан” арван боть хэвлэгдээд



Доктор (Sc.D), профессор С.Чулуун ОХУ-ын Эрмитажын Улсын музейн захирал Пиотровский хамт Санкт-Петербург хот. 2013.09.26.

байгаагаас гадна Монголын угсаатны бүлгүүдээр 20 орчим боть бүтээл нэгэнт бичигдэж, Монголын түүхийн 25 боть бүтээлийг туурвих судалгааны ажил эхлээд байна. Монголын угсаатны зүйн музей-лаборатори, Монголын археологийн музей-лаборатори байгуулах явдал ч захирал С.Чулууны нэг том зорилго юм.

Монгол улсын түүх судлалын хамрах хүрээ, чиглэлийг бүс нутгийн судалгаа явуулдаг олон улсын байгууллагуудтай хамтран оновчтой тодорхойлох, олон улсын судалгааны байгууллагуудтай нягт хамтран ажиллах бодлогыг С.Чулуун идэвхтэй явуулж, 2011 онд БНСУ-ын Зүүн хойд Азийн түүхийн сангийн “Монгол-Солонгосын түүхч, археологичдын холбоо”, 2015 онд Лейдений Ази, Африк судлалын хүрээлэнгийн “Төв болон дотоод Азийн судалгааны салбар”, 2016 онд Япон улсын Хүмүүнлэгийн Үндэсний хүрээлэнгийн “Зүүн хойд Азийн хөтөлбөрийн төв”-ийг тус хүрээлэнгийн дэргэд байгуулснаар Монголын түүхчид бүс нутгийн судалгааны

төвүүдтэй хамтран ажиллах өргөн боломж нээгдэж, улмаар Түүх, археологийн хүрээлэн дэлхийн монгол судлалын төв болж хөгжих чиг хандлага нэгэнтээ тогтоод байна.

Профессор С.Чулууны эрдэм шинжилгээний үйл хэрэг, ажил хөдөлмөр, бүтээл туурвилыг Монгол улсын төр засаг өндрөөр үнэлж, “Хөдөлмөрийн хүндэт медаль” (2011), “Алтан гадас одон” (2016), “Шинжлэх ухааны тэргүүний ажилтан” цол тэмдэг (2011), Чингүнжавын одон (2010)-оор шагнажээ. Түүнчлэн 2009, 2011 оны “Шилдэг залуу эрдэмтэн”, МУИС-

ийн шилдэг судлаач багш (2010), Жек Уотэрвордын оны шилдэг бүтээлийн шагнал (2012), БСШУСЯ-ны шилдэг бүтээлийн шагнал (2014, 2015)-аар шагнагдсан төдийгүй ОХУ-ын ШУА-ийн дорно дахин судлаачдад олгодог дээд шагнал “И.Я.Крачковскийн алтан медаль” (2014), БНХАУ-ын Багшийн Их сургуулийн хүндэт доктор (2014), Япон улсын Элчин сайдын хүндэт өргөмжлөл (2015)-ийг хүртсэн эрдэмтэн юм.

Доктор, профессор Г.Мягмарсамбуу

ЗҮҮН АЗИЙН ОЛОН УЛСЫН БАГА ХУРАЛ УЛААНБААТАР ХОТНОО ЧУУЛНА

2018 оны 6 дугаар сарын 29-нөөс 7 дугаар сарын 2-ны өдрүүдэд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотноо Зүүн Азийн Слав-Еврази судлалын олон улсын IX бага хурал анх удаа зохион байгуулна. Энэхүү бага хурлыг Төв, Зүүн Европ Судлалын Монголын Холбоо, ШУА-ийн Олон улсын харилцааны хүрээлэнтэй хамтран зохион байгуулахаар ажиллаж байна.

Зүүн Азийн бүсийн бага хурал нь 2007 оноос International Council for Central and Eastern Europe Studies (ICCEES) холбооны хүрээнд зохион байгуулж эхэлсэн бөгөөд бага хуралд БНСУ, Япон, БНХАУ, Энэтхэг, Монгол, Казахстан зэрэг Азийн орны Слав-Еврази судлаачид тогтмол оролцдог уламжлалтай болсон билээ. Энэ нь Ази тивийн төлөөлөгчдөөр хязгаарлагдахгүй, ICCEES холбооны удирдах зөвлөлийн гишүүд, Баруун Европ, АНУ, Канад, Австрали зэрэг өндөр хөгжилтэй орны энэ чиглэлийн судлаач эрдэмтэд, их дээд сургуулийн багш, профессорууд оролцдог чухал арга хэмжээ юм. Иймд эрдэмтэн судлаачид судалгааны үр дүн, шинэ мэдээ, мэдээлэл, туршлага, байр сууриа солилцдог чухал индэр болж төлөвшсөн билээ.

ICCEES нь 1974 онд байгуулагдсан, Төв, Зүүн Европын орны судлалаар мэргэшсэн дэлхийн 50 гаруй орны эрдэмтэн судлаачдыг сайн дурын үндсэн дээр өөрийн эгнээндээ нэгтгэсэн олон улсын ТББ юм. ICCEES холбоо 5 жил тутам их хурал зохион байгуулдаг бөгөөд сүүлийн IX их хурал 2015 онд Японы Макухарид хотод, X их хурал 2020 онд Канадын Монреаль хотод зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Их хурлын завсраар бүсийн, тухайлбал Зүүн Азийн олон улсын бага хурлыг зохион байгуулж байна. Төв Зүүн Европ судлалын Монголын Холбоо нь 2012 онд Орос, Европ судлалын эрдэмтэн судлаач, их дээд сургуулийн багш, профессор нарын санаачлагаар анх байгуулагдсан бөгөөд 2013 онд ICCEES холбооны гишүүн болж, 2013 оноос Зүүн Азийн Слав-Еврази судлалын олон улсын бага хуралд оролцож эхэлсэн юм.

2018 оны 6 дугаар сард Сөүл хотноо болсон Азийн орнуудын Төв, Зүүн Европ судлалын холбоодын удирдлагуудын дээд хэмжээний уулзалтаас Зүүн Азийн Слав-Еврази судлалын олон улсын IX бага хурлыг 2018 оны 6 дугаар сарын